

# Дахин амилалт

-The Resurrection-



146Page

**Тайлбарлагч**

Есүсийг нас бархад дагалдагч нар болон Түүнийг дагадаг байсан хүмүүс ихэд гуниглан гашуудацгаажээ. Ромын ахлах тахилч болон удирдагч нар Есүс үхээд гурав хоногийн дотор амилах болно гэсэн үгнээс болж Есүсийг оршуулсан хадан булшийг цэргүүдээр мануулав.



147Page

**Тайлбарлагч**

Есүс нас бараад гурав дахь хоног болов. Энэ өдрийн үүрээр Магдалын Мариа болон Иаковын ээж Мариа, Иоханна нар булшийг эргэхээр хамт явцгаав. Тэд Есүсийн биенд анхилуун үнэрт тос түрхэхээр явж байв. Булшинд иртэл булшны ам нээлттэй байхыг хараад ихэд гайхан сандралдав. Ороод үзтэл Есүсийн цогцос алга байв. Тэд маш их гайхан яах учраа олохгүй байтал Есүсийн хэвтэж байсан чулуун дээр нэгэн тэнгэр элч сууж байхыг харлаа.

**Тэнгэр элч**

Та нар бүү айгтун. Есүс одоо энд байхгүй. Тэр үхлээс дахин амь орсон.



148Page

**Тайлбарлагч**

Тэд энэ баярт мэдээг сонсгох гэж яаран гүйцгээв. Гүйх замдаа нэг хүнтэй тааралдахад тэр нь Есүс байв. Тэд ихэд баярлан Есүсийн хөлд сөгдөн унаж, хөлнөөс зуурч мэндчлэв. Гэтэл Есүс харагдахаа болив.

**Есүс**

Та нар дагалдагч нарт очоод надтай уулзсаныг мэдүүл. Би Галилд очиж дагалдагч нартайгаа уулзах болно.



149Page

**Тайлбарлагч**

Тэр өдрийн орой нь дагалдагч нар нь Иерусалимын нэгэн дээврийн өрөөнд цугласан байлаа. Тэд Ромын цэргүүд өөрсдийг нь ирээд бариад авчих вий хэмээн ихэд айж хаалгаа сайтар түгжсэн байлаа. Тэр үед, Есүс дагалдагч нарынхаа өмнө үзэгдэв.

**Есүс**

Амар тайван нь та нарын дээр байх болтугай

**Тайлбарлагч**

Тэд сүнс харсан мэт маш их айн чичэрцгээж байв. Есүс тэдэнд хандан:

**Есүс**

Юунд тэгтлээ гайхна вэ? Та нар намайг ингэж харж байгаа нь амилсан гэдэгт маань эргэлзэж байна уу? Миний гар болон биеийг бариад үз.



150Page

**Тайлбарлагч** Дагалдагч нар ингэж нэг Түүнийг дахин амилсанд итгэв. Тэд Есүстэй уулзсандаа маш баяртай байлаа. Амилсан Есүсийн өмнө өвдөг сөгдөн Түүнд мөргөв.

Бурханы Хүү Есүс, хүмүүсийн гэмийн төлөө загалмай дээр нас барсан боловч ингэж гурав хоногийн дотор дахин амь орсон юм.

.....

**Тайлбарлагч** Есүс дагалдагч нартаа ингэж хэлэв.

**Есүс** Та нар энэ баярт мэдээг дэлхийн бүх хүмүүст дамжуул, зааж сурга. Тэгээд тэдэнд баптисм хүртээ. Би үеийн төгсгөл хүртэл та нартай үргэлж хамт байх болно.

**Тайлбарлагч** Есүс дэлхийн төгсгөлийг шүүхээр үүл хөлөглөн дахин бууж ирнэ гэж амласан.